



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А1200

Улаанбаатар хот

"Эрүүл мэндийн технологи - 2026"
үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн технологи - 2026" үзэсгэлэнг 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. "Эрүүл мэндийн технологи-2026" үзэсгэлэнг зохион байгуулах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, шилдэг оролцогчийг шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар, шилдэг оролцогчийг шалгаруулах шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. "Эрүүл мэндийн технологи - 2026" үзэсгэлэнгийн бэлтгэл хангаж, зохион байгуулан ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н. Эрдэнэбаяр)-д даалгасугай.


САЙД



Э.БАТШУГАР

141260975

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 06 дугаар
сарын 16 өдрийн 1/20 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2026" ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Ажлын хэсгийн дарга дэд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга

Гишүүд: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Д.Энхжаргал Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо ТББ-ын ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)

М.Бат-Эрдэнэ, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн (зөвшилцсөнөөр)

И.Балжинням, Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)


С.Пүрэвсүрэн, АШУУИС-ын Эм зүйн сургуулийн багш, Эм зүйн ухааны доктор, профессор. (зөвшилцсөнөөр)

С.Удвал, Сая Мөнх ХХК-ний гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг: Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж хариуцсан мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын ахлах мэргэжилтэн

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 06 дугаар
сарын 16 өдрийн 12 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ - 2026" ҮЗЭСГЭЛЭНГИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго, үндэслэл:

Эрүүл мэндийн салбар, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтэрч буй эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, оношилгооны дэвшилтэт технологи, арга аргачлалыг олон нийтэд таниулах зорилгоор эрүүл мэндийн технологи үзэсгэлэнг төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран жил бүр зохион байгуулж, гадаад, дотоодын оролцогчдын тоо нэмэгдсээр байна.

Монгол Улс болон Олон улсын эрүүл мэндийн салбарт нэвтэрсэн шинэ эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологи, арга аргачлалыг олон нийтэд сурталчлан таниулах, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг олон нийтэд сурталчлах зорилгоор "ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ 2026" олон улсын үзэсгэлэнг зохион байгуулна.

Хоёр. Хугацаа, байршил:

"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2026" үзэсгэлэнг Улаанбаатар хот Баянгол дүүрэгт байрлах "М Банк" Арена төвийн байранд 2026 оны 09 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн шинэ эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг таниулах;

Дотоодын үйлдвэрлэгч, импортлох-ханган нийлүүлэгч байгууллагын дэвшилтэт технологи, инновац шингэсэн шинэ бүтээгдэхүүнийг танилцуулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

Олон улсын үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд сурталчлан таниулах;

Эрүүл мэндийн технологи, эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг таниулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, харилцан туршлага солилцох.

Шинээр танилцуулагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийн талаар эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтууд зохион байгуулах.

Дөрөв. Хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн байгууллага;
- Дотоод болон гадаадын үйлдвэрлэгчид;
- Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох-ханган нийлүүлэх байгууллага;
- Сургалт, судалгаа, боловсролын байгууллага;
- Худалдааны төлөөлөгчийн газар, албан ёсны дистрибьютер;
- Төрийн болон төрийн бус бусад байгууллага.
- Төрийн бус байгууллага.

Тав. Зохион байгуулагч:

Үндсэн зохион байгуулагч:

- Эрүүл мэндийн яам;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар.

Хамтран зохион байгуулагч:

- Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "ЭМ" холбоо;
- Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг;
- Сая Мөнх ХХК.

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 06 дугаар сарын 16. өдрийн 1209 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ- 2026" ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШИЛДЭГ ОРОЛЦОГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга

Гишүүд: Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан ахлах шинжээч

Д.Энхжаргал, Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо ТББ-ын ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газрын ахлах, улсын ахлах байцаагч

Д.Жамбанинж, АШУҮИС-ын Эм зүйн сургуулийн багш, Эм зүйн ухааны доктор, дэд профессор (зөвшилцсөнөөр)

И.Балжинням, Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Н.Гэрэлт-од, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн гишүүн (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм зүйн салбарын сургалт, судалгаа, шинжилгээ, статистик бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Б.Буянчимэг, Монголын эмзүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо ТББ-ын нарийн бичиг (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 06 дугаар
сарын 16. өдрийн 12 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт



"ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2026" ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШИЛДЭГ ОРОЛЦОГЧДЫГ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

"Эрүүл мэндийн технологи-2026" үзэсгэлэнгийн шилдэг оролцогчдыг дараах шалгаруулах шалгуурын дагуу тодруулна.

1. "ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ"

- Эм үйлдвэрлэлийн зохистой дадал хэрэгжүүлснийг гэрчлэх (GMP) батламжтай байх;
- Эмийн хяналтын лаборатори нь MNS/ISO 17025 стандартаар итгэмжлэгдсэн байх;
- Хяналт шалгалтаар 2024, 2025 онд бага эрсдэлтэй үнэлэгдсэн байх;
- Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд харгалзах зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь;
- 2023, 2024, 2025 онд шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо;
- 2023, 2024, 2025 онд үйлдвэрлэлд нэвтрүүлсэн инновац шингэсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо;
- 2023, 2024, 2025 онд шинээр бий болгосон ажлын байрны төрөл, тоо;
- Мэргэжлийн хүний нөөцийн мэргэжил дээшлүүлсэн байдал;
- 2023, 2024, 2025 онд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлан;
- Тайлан мэдээг тогтмол, хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлдэг, эмийн тасалдал үүсгэдэггүй байх.

2. "ШИЛДЭГ ИМПОРТЛОГЧ БАЙГУУЛЛАГА"

- Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- Хяналт шалгалтаар 2024, 2025 онд бага эрсдэлтэй үнэлэгдсэн байх;
- 2023, 2024, 2025 онд Монгол Улсын эмийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн эмийн жагсаалт, шинээр нэвтрүүлсэн төсөл хөтөлбөр, оношилгоо, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлсэн байх;
- 2023, 2024, 2025 онд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлан;
- Тайлан мэдээг тогтмол, хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлдэг, эмийн тасалдал үүсгэдэггүй байх.

3. "ШИЛДЭГ ИННОВАЦ ШИНГЭЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН"

- Байгууллагын танилцуулга;

- 2023, 2024, 2025 онд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүний танилцуулга;
- Оюуны өмчийн гэрчилгээ;
- Дэвшилтэт технологи шингээсэн болохыг нотлох баримт;
- Импортыг орлох чадамжтайг харуулсан тайлан;
- Шинэлэг бүтээгдэхүүн эсэхийг нотлох судалгаа, түүний үндэслэл;
- Зах зээлд нэвтрүүлсэн тайлан.

4. "ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН"

- Байгууллагын танилцуулга;
- Бүтээгдэхүүний танилцуулга;
- 2023, 2024, 2025 оны борлуулалтын тайлан;
- Оношилгоо, эмчилгээний давуу тал, ач холбогдлыг нотолсон бичиг баримт;
- Зах зээлд нэвтрүүлсэн тайлан.

5. "ШИЛДЭГ ДЭВШИЛТЭТ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ"

- Байгууллагын танилцуулга;
- 2023, 2024, 2025 онд шинээр оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлсэн тоног төхөөрөмжийн танилцуулга;
- Дэвшилтэт технологи шингээсэн болохыг нотлох баримт бичиг;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн оношилгоо, эмчилгээний давуу тал, ач холбогдлыг нотлох баримт бичиг;
- Зах зээлд нэвтрүүлсэн тайлан.

6. "ШИЛДЭГ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА"

- Байгууллагын танилцуулга;
- 2023, 2024, 2025 онд шинээр нэвтрүүлсэн технологийн танилцуулга;
- Оношилгоо, эмчилгээний давуу тал, ач холбогдлыг нотолсон баримт бичиг;
- Оношилгоо, эмчилгээний үр дүнгийн тайлан;
- Дэвшилтэт технологи шингээсэн болохыг нотлох баримт бичиг.

7. "ШИЛДЭГ ОРОЛЦОГЧ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ИМПОРТЛОХ-ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА"

- Байгууллагын танилцуулга;
- Дизайны өвөрмөц шийдэл;
- Идэвх оролцоо;
- Үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан.

8. "ШИЛДЭГ ОРОЛЦОГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА"

- Байгууллагын танилцуулга;
- Дизайны өвөрмөц шийдэл;
- Идэвх оролцоо;

- Үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан.

9. "ШИЛДЭГ ОРОЛЦОГЧ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА"

- Байгууллагын танилцуулга;
- Дизайны өвөрмөц шийдэл;
- Идэвх оролцоо;
- Үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан.